

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Г Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Эдийн засаг, хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтцийг доор дурдсанаар баталсугай:

2.1.Макро эдийн засгийн бодлогын газар (Судалгаа, шинжилгээний хэлтэс, Бодлого, төсөөллийн хэлтэс, Өрсөлдөх чадварын судалгааны хэлтэстэй);

2.2.Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар (Салбарын нэгдсэн бодлогын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэстэй);

2.3.Бус, орон нутгийн хөгжлийн бодлогын газар;

2.4.Хөрөнгө оруулалтын бодлогын газар (Үйлдвэржилт, дэд бүтцийн хэлтэс, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэстэй);

2.5.Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газар (Худалдааны хэлтэс, Чөлөөт бусийн хэлтэстэй);

2.6.Инновацын бодлогын газар;

2.7.Төрийн захиргааны удирдлагын газар (Санхүүгийн хэлтэс, Хуулийн хэлтэстэй);

2.8.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

3.Эдийн засаг, хөгжлийн яамны орон тооны хязгаарыг 135 байхаар тогтоосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай” Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 75 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2023 оны 05 дугаар  
сарын 03 -ны өдрийн 16 дүгээр  
тогтоолын хавсралт

## ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

#### 1.1. Оршил

Эдийн засаг, хөгжлийн яам (цаашид “яам” гэх)-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Монгол Улсын Засгийн газар болон Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд (цаашид “сайд” гэх)-ын эрхлэх асуудлын хүрээнд сайдын болон Засгийн газрын танхимын шийдвэрийн төслийг боловсруулан гárгах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, макро эдийн засгийн судалгаа шинжилгээ, бодлого төсөөлөл гаргах, нэгдсэн бодлого төлөвлөх, салбарын болон нийгмийн хөгжлийн бодлогын уялдаа холбоог хангах, бус, орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын бодлого, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал, инновацийн тогтолцооны бодлого, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг боловсруулахад оршино.

#### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэтгэлийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн боловсруулав.

#### 1.3. Хууль, эрх зүйн орчин

1.3.1. Хөтөлбөрийг доор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;

- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Чөлөөт бусийн тухай хууль;
- Инновацийн тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
  - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
  - бусад холбогдох хууль тогтоомж.

#### 1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомжид орсон өөрчлөлт, сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүргүүдэд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлэн, засаглал, төрийн захиргааны шинэчлэлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, байгууллагын өөрчлөлтөд үндэслэн олон улсын туршлага, бусад төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын

бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт харьцуулалт хийх замаар нийтлэг арга зүйг ашиглаж, тус яамны үйл ажиллагааны мөн чанар, тэргүүлэх чиглэл, эрхэм зорилго, стратегийн гол зорилт болон зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг уургийг тодорхойлов.

## 1.5. Яамны үүрэг, хариуцлагын хуваарь

Яам нь эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хууль тогтоомж, бодлого, стратегийг төлөвлөх, боловсруулах, хөгжлийн бодлогыг үндэсний хэмжээнд нэгдсэн уялдаагаар хангах үүрэг, хариуцлага хүлээж, сайд болон Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлнэ. Яам нь үндэсний хөгжлийн бодлогыг төлөвлөх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, салбар хооронд болон бус нутаг, орон нутгийн хэмжээнд нэгдсэн бодлого, уялдаагаар хангах асуудалд өргөн цар хүрээтэй, шинжлэх ухааны судалгаа, үндэслэлтэй хандаж, зөв зохицтой удирдана.

## 1.6.Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, тэр дундаа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой бүрэн тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг тодорхойлоход чухал ач холбогдолтойг харгалзан энэ хэрэгцээний эх үүсвэрт дараах үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг хамруулав:

Эдийн засаг, хөгжлийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний  
эхүүсвэр



Яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь сайд, Засгийн газар (танхим) байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн зорилт, чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

### Хоёр. Яамны үйл ажиллагааны стратеги

#### 2.1.Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь холбогдох бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын тогтвортой хөгжил, эдийн засгийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилго, гол зорилтуудыг оновчтой, зөв тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхдээ судалгаа, шинжилгээнд үндэслэсэн өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон бодлого, арга хэмжээгээр сайд, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийг хангаж, тэдгээрт бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх явдал юм.

#### 2.2.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Яам нь доор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй байна:

2.2.1.макро эдийн засгийн судалгаа, шинжилгээнд сууринсан бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн ирээдүйн төсөөлөл, төлөвлөлт хийх;

2.2.2.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, салбар, салбар хоорондын нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;

2.2.3.орон зайн хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, салбарын хөгжлийн байршлыг оновчтой төлөвлөх, зохистой харьцааг тогтоох, түүнд нийцүүлэн салбарын байршил төлөвлөлт, чиглэлийг тодорхойлох, хөгжлийн төслүүдийг төлөвлөх;

2.2.4.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх;

2.2.5.хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, зээл, тусlamжийн нэгдсэн бодлого болон худалдаа, чөлөөт бүсийн бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах;

2.2.6.өндөр технологи, үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх бодлого тодорхойлж, төлөвлөлт хийх, яамны эрхлэх асуудлын хүрээний мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх;

2.2.7.яамны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, төрийн захиргааны удирдлагын манлайллыг бий болгох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;

2.2.8.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх.

### 2.3.Эрхэм зорилго

Яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийг төлөвлөх, хөгжлийн нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах замаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхыг тогтвортой, хүртээмжтэй дээшлүүлэхэд оршино.

### 2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Яам нь үйл ажиллагааныхаа эрхэм зорилгынхоо хүрээнд доор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1.макро эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлтийг боловсруулах;

2.4.2.Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, салбар, салбар хоорондын, бус, орон нутгийн уялдааг ханган боловсруулах, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлох;

2.4.3.хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн бодлого, салбарын хөгжлийн оновчтой байршлыг тогтоож, бус, орон нутгийн хөгжлийг тодорхойлж, дэд бүтэц, хөнгөн, жижиг, дунд, хүнд болон аж үйлдвэрийн байршил тодорхойлох, төлөвлөлтөөр хангах;

2.4.4.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хөгжлийн төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, хөрөнгө оруулалтыг татах, дэмжих, хамгаалах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.4.5.худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад зээл, тусламж, чөлөөт бүсийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;

2.4.6.өндөр технологи, үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх нэгдсэн бодлогыг тодорхойлж, салбарыг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах;

2.4.7.төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, санхүү, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүй болон гадаад харилцаа,

хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах;

2.4.8.үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

## 2.5.Үйл ажиллагааны гол зорилт

Энэхүү хөтөлбөрийн 2.4-т заасан яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дараах гол зорилтыг хэрэгжүүлнэ:

### 2.5.1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1.макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;

2.5.1.2.эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл хийх;

2.5.1.3.эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох;

2.5.1.4.улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

2.5.1.5.өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор судалгаа, шинжилгээнд үндэслэн бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.

### 2.5.2.Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах;

2.5.2.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж улс, салбар, салбар хооронд нэгтгэн зохион байгуулах, уялдааг хангах, арга зүйн зөвлөгөө өгөх;

2.5.2.3.хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийн үйл ажиллагааг удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах;

2.5.2.4.олон улсын хөгжлийн туршлага, чиг хандлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх;

2.5.2.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээллийг эргэлтэд оруулах;

2.5.2.6. улсын төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх;

2.5.2.7. эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл болон эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох хүрээнд салбаруудын мэдээллийн бааз суурийг бэхжүүлж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. орон зайн хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулж, бус, орон нутгийн төлөвлөлтийг уялдуулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг бус, орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.5.3.2. бус, орон нутгийн нийгэм, соёлын хөгжлийг харьцангуй жигд хангахад чиглэсэн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарын хөгжил, байршлыг тодорхойлох, оновчтой төлөвлөх, зохистой харьцааг тогтоох;

2.5.3.3. хөнгөн, жижиг, дунд, хүнд үйлдвэр, дэд бүтцийн болон салбарын хөгжлийн байршлыг төлөвлөхөд нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.5.3.4. бус, орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагчид болон олон улсын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авах;

2.5.3.5. эдийн засгийн суурь болох хүн ам, хөдөлмөрийн нөөц, эдийн засгийн эргэлтэд оруулах малын гаралтай түүхий эд, ус, газрын баялгийн нөөцийн судалгааг байршилаар нь нарийвчлан хийж, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн төсөөллийг боловсруулж, нөөцийг ашиглах оновчтой арга замыг тодорхойлох, нөөцөд түшиглэн кластераар бүсчлэн хөгжүүлэх бодлогыг боловсруулах;

2.5.3.6. орон зайн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол баяжуулан шинэчлэх, хянах, мэдээллийг эргэлтэд оруулах;

2.5.3.7. орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулах;

2.5.3.8. бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.5.3.9. аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, санал өгөх.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1.хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжлийн төслийг тодорхойлж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах;

2.5.4.2.хөрөнгө оруулалтын тухай, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангуулах, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын олон улсын гэрээ байгуулах асуудлаар санал боловсруулах;

2.5.4.3.хөрөнгө оруулагч, хувийн хэвшлийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;

2.5.4.4.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоон эрэмбэлэх, хянан баталгаажуулах, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийлгэх, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах;

2.5.4.5.бэлэн байдал хангагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг хянах;

2.5.4.6.төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулах;

2.5.4.7.хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтвортжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;

2.5.4.8.нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Хөрөнгө оруулалт, худалдааны газар болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавих.

2.5.5.Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1.хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах;

2.5.5.2.худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бус нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, салбар хоорондын уялдааг хангах;

2.5.5.3.хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусlamжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

2.5.5.4.худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлох, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.5.5.5.Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.5.5.6.чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих.

#### 2.5.6.Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1.өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцооны урт, дунд хугацааны бодлого боловсруулж, төлөвлөлт хийх, инновацийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;

2.5.6.2.үндэсний инновацийн тогтолцоо, инновацийн үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааны уялдааг хангах;

2.5.6.3.эрхлэх асуудлын хүрээний болон хууль тогтоомжид заасан мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх.

#### 2.5.7.Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1.төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

2.5.7.2.иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

2.5.7.3.Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;

2.5.7.4.эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааг нэлтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

2.5.7.5.сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх;

2.5.7.6.салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах;

2.5.7.7.яамны гадаад, дотоод хамтын ажиллагааг хариуцан бодлого, үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн харилцааг зохицуулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

2.5.7.8.сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдан чиглүүлэх.

#### 2.5.8.Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

2.5.8.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэлтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.5.8.2.Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.5.8.3.улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;

2.5.8.4.яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр үүрэг болгосон ажил үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;

2.5.8.5.хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан яамны хариуцах болон хамтран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;

2.5.8.6.яамны дотоод нэгж, сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, Шилэн дансны тухай хуулийн

хэрэгжилтэд хяналт шалгалт, дотоод аудит хийж, эрсдэлийн удирдлагаар хангах, зохих арга хэмжээг авах талаар зөвлөмж өгөх.


#### 2.6.Үйл ажиллагааны зорилт

Яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

#### 2.7.Үйл ажиллагааны стратегийн загвар

Яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг доор дурдсанаар тодорхойлж байна:

## Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратегийн загвар



Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хөгжлийн төслийдийг үнэлэх, эрэмбэлэх, хөрөнгө оруулалтыг татах, дэмжих, хамгаалах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх

-хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэржилт, дэд бүтцийн хөгжлийн төслийг тодорхойлж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах;  
-хөрөнгө оруулалтын тухай, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын олон улсын гэрээний хэрэгжилтийг хангуулах, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын олон улсын гэрээ байгуулах асуудлаар санал боловсруулах;  
-хөрөнгө оруулагч, хувийн хэвшлийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлох, зохицуулалтыг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах;  
-улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн тесэл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоон эрэмбэлэх, хянан баталгаажуулах, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг тесэл хийлгэх, бэлэн байдлыг хангуулах ажлыг уялдуулан зохион байгуулах;  
-бэлэн байдал хангагдсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төслийдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслийдийг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтийг хянах;  
-тер, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнзлэгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулах;  
-хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтвортжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;  
+нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Хөрөнгө оруулалт, худалдааны газар болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор хангах, чиглүүлэх, хяналт тавих.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад зээл, тусlamж, чөлөөт бусийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих

-хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах, мөн хэрэгжилтийн үр ашигийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах;  
-худалдаа, эдийн засаг, санхүүгийн асуудлаар түнш орон, олон улсын болон бус нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, салбар хоорондын уялдааг хангах;  
-хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусlamжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх тесэл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч талуудын хамт тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;  
-худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг баагасгаж, хөнгөвчлөхэд чиглэсэн бодлогыг тодорхойлох, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;  
-Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашигийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавих;  
-чөлөөт бусийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих.

Өндөр технологи, үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх нэгдсэн бодлогыг тодорхойлж, салбарыг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах

-өндөр технологи, үндэсний инновацын тогтолцооны урт, дунд хугацааны бодлого боловсруулж, төлөвлөлт хийх, инновацын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;  
-үндэсний инновацын тогтолцоо, инновацын үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааны уялдааг хангах;  
-эрхлэх асуудлын хүрээний болон хууль тогтоомжид заасан мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх.

Төрийн захирагааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, санхүү, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүй болон гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл, олон нийтгэй харилцах асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах

-төрийн захирагааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгох, албан хаагчдын ажиллах нехцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх; -иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүснэгтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

-Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;

-эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

-сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцаа, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг ханггуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх;

-салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, тесөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах;

-яамны гадаад, дотоод хамтын ажиллагааг хариуцан бодлого, үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн харилцааг зохицуулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

-сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдан чиглүүлэх.

Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх

-Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж гаргах;

-Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

-улсын тесөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа тесөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих; -яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр үүрэг болгосон ажил үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;

-хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан яамны хариуцан болон хамтран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих, сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад тайлагнах;

-яамны дотоод нэгж, сайдын эрхлэх асуудлын хүрээний тесөвт байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, тесвийн хөрөнгө, орлого, зарлага, тесөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалаа, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, зохих арга хэмжээг авах талаар зөвлөмж өгөх.

## Гурав. Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн чиг үүрэг

### 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав:

3.1.1. яамны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх (яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо буюу зохион байгуулалтын бүтэц нь

энэхүү хөтөлбөрийн үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдаж боловсруулагдсан);

3.1.2.эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх (яамны бүтцийн нэгж тус бүрийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхой заагласан бөгөөд зохион байгуулалтын бүтцэд удирдах, гүйцэтгэх албан тушаалын шатлан захирах ёсны зарчим бүрэн хангагдсан, мөн бусад төрийн байгууллагуудын чиг үүрэгтэй давхардахгүй байгаа болно);

3.1.3.үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх (хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцээс яамны үйл ажиллагааны чиглэл, хэрэгжилтийг нь хангах хууль тогтоомжийн талаар болон зохион байгуулалтын нэгж тус бүрийн нэршлээс гүйцэтгэх чиг үүргийг шууд дүгнэх боломжтой);

3.1.4.бүтцийн хувьд энгийн байх (яамны Төрийн нарийн бичгийн даргаас албан хаагч хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байна);

3.1.5.тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоосон байх (яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар хялбар аргаар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэх байдлаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүний болон бусад нөөцийг зөв хуваарилан, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байна);


3.1.6.улс төрөөс ангид байх (яамны албан хаагчид нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх мэдлэг, туршлагатай, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан байна);

3.1.7.хангалттай чадавхтай, бодитой үйл ажиллагаатай байх (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь үйл ажиллагааны давхардалгүй, чадавхаа бүрэн дүүрэн илрүүлэх, дайчлан ажиллахад чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байна).

### 3.2.Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон яамны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг дараах байдлаар тогтоосон:

**Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны  
бүтцийн өрөнхий тогтолцооны загвар**



### 3.3. Яамны зохион байгуулалтын бүтэц

#### 3.3.1. Макро эдийн засгийн бодлогын нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд макро эдийн засгийн бодлогын судалгаа, үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлтийг хийж, бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлон нийгэм, эдийн засгийн нөлөөллийг тооцох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад макро эдийн засгийн бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн зөвлөгөө, шуурхай үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар (танхим), сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад нэгж байх ба шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллага байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд судалгаа, шинжилгээний нэгж, бодлого, төсөөллийн нэгж болон өрсөлдөх чадварын судалгааны нэгж ажиллана:

### 3.3.1.1.Судалгаа, шинжилгээний нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь эдийн засгийн нөхцөл байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэл, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.1.2.Бодлого, төсөөллийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт хийх, эдийн засгийн тогтвортой байдал, өсөлтийг хангах бодлогын чиглэлийг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.1.3.Өрсөлдөх чадварын судалгааны нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн олон улс дахь эрэмбийг ахиулах зорилгоор нэгдсэн тооцоолол, судалгаа, шинжилгээнд үндэслэн холбогдох бүх шатны төрийн байгууллагуудыг бодлогын нэгдсэн удирдлага, зохицуулалт, зөвлөмжөөр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.2.Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагын дагуу салбар, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэл, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлж, чиг үүргийнхээ хүрээнд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжлийн бодлого, төлөвлөлтэд холбогдох мэдээллээр яамны бусад нэгжийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад хөгжлийн бодлого, төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн зөвлөгөө, шуурхай үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар (танхим), сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад нэгж байх ба шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллага байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд салбарын нэгдсэн бодлогын нэгж болон нийгмийн хөгжлийн нэгж ажиллана:

### 3.3.2.1. Салбарын нэгдсэн бодлогын нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогыг тодорхойлох, төлөвлөх, салбар, салбар хоорондын бодлогыг уялдуулж, нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.2.2. Нийгмийн хөгжлийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлогыг тодорхойлох, нэгдсэн арга зүй, удирдамжаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.3. Бус, орон нутгийн хөгжлийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн З дугаар зорилтын хүрээнд хүн амын нутагшил, суурьшлын ерөнхий төлөвлөлт, байршлыг тогтоож, түүнд үндэслэн бус, орон нутгийн орон зайн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг удирдан зохион байгуулах, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдуулан аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон жилийн төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, орон зайн төлөвлөлтийн мэдээллийн системийг хөгжүүлэх, дэд бүтцийн нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр хангах, хөгжлийн төслүүдийг тодорхойлж, дэмжлэг, удирдлагаар хангах, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь орон зайн төлөвлөлт дээр суурилан боловсруулсан бус, орон нутгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, нөөцийн мэдээлэл, авто зам, төмөр зам, тээвэр логистик, агаарын тээвэр, эрчим хүч, өндөр технологи, инновацийн чиглэл, байршил болон бусад холбогдох мэдээллийг боловсруулж, хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох мэдээллээр яамны бусад нэгж, төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгжийг хангах, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад Засгийн газрын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сайдад шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн зөвлөгөө, шуурхай үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар (танхим), сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад нэгж байх ба шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, холбоод, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн байна.

### 3.3.4 Хөрөнгө оруулалтын бодлогын нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах, хөгжлийн төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, хөрөнгө оруулалтыг татах, дэмжих, хамгаалах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг нэгтгэн зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгж нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтвортжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх үүргийг хүлээнэ. Мөн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, судалгааг боловсруулж нэгдсэн бодлогод тусгуулж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, төслийн удирдлагын төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сайдад шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн зөвлөгөө, шуурхай үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар (танхим), сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад нэгж, Хөрөнгө оруулалт, худалдааны газар болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв байх ба шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, холбоод, олон улсын байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, иргэн, хуулийн этгээд байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд үйлдвэржилт, дэд бүтцийн нэгж болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгж ажиллана:

### 3.3.4.1.Үйлдвэржилт, дэд бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төсөл, хөтөлбөрийг тодорхойлж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, үйлдвэржилт, дэд бүтэц, хөгжлийн төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч, үнэлэх, сонгох, тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоон эрэмбэлэх, хянан баталгаажуулах, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийлгэх, бэлэн байдлыг хангах, бэлэн байдал хангагдсан төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, төслийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.4.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээг холбогдох хууль, журамд заасны дагуу салбарын яам, түншлэлийн төвөөр хийлгэх, хамтран оролцох, хяналт тавих, түншлэлийн төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгуулах, түншлэлийн төслийн саналыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, түншлэлийн төслийн уралдаант сонгон шалгаруулалт зохион байгуулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангах, гэрээний биелэлт, явц, үр дүнд хяналт тавих арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах арга хэмжээг уялдуулан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.5.Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, түнш орон, олон улсын болон бус нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, зээл, тусlamжийн бодлогыг тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн зөвлөгөө, шуурхай үйлчилгээ үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар (танхим), сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад нэгж, Хөрөнгө оруулалт, худалдааны газар болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв байх ба шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, холбоод, олон улсын байгууллага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, иргэн, хуулийн этгээд байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд худалдааны нэгж, чөлөөт бүсийн нэгж ажиллана:

#### 3.3.5.1. Худалдааны нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь импортыг орлох салбарыг дэмжиж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах, худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөх бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

#### 3.3.5.2.Чөлөөт бүсийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангувж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

#### 3.3.6.Инновацын бодлогын нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд өндөр технологи, үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэх урт, дунд хугацааны нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавихад чиглэж ажиллах ба инновацын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, инновацын үйл ажиллагаанд оролцогчдыг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах, үндэсний инновацын

хөгжлийн түвшнийг үнэлэх аргачлал боловсруулах, мөрдүүлэх, хууль тогтоомжид хөтлөхөөр заасан мэдээллийн сангудын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад Засгийн газрын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, сайдад шаардлагатай мэдээлэл, мэргэшлийн өндөр түвшний судалгаа, зөвлөгөө, бодлогын хувилбараар шуурхай үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар (танхим), сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад нэгж байх ба шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд байна.

### 3.3.7. Төрийн захиргааны удирдлагын нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд төрийн байгууллагын хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж, цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий хүний нөөцийн удирдлагаар яамны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж, тайлагнах, хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг нэгтгэн гаргах ажлыг зохион байгуулах, тайлагнах, аппаратын дотоод ажлыг эрхлэх, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах, салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих, байгууллагын санхүүг эрхлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлагууд, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ нэгжийн үйлчилгээний гол түвш нь Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд санхүүгийн нэгж болон хуулийн нэгж ажиллана:

#### 3.3.7.1. Санхүүгийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулах, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохицуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, ерөнхийлөн захирагчийн болон яамны аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.7.2.Хуулийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дээд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

### 3.3.8.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд улсын хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, яамны үйл ажиллагаанд шууд хамаарах хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусlamж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, зөвлөмж гаргах, биелэлтэд хяналт тавих, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон яамны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах болон эрсдэлийн удирдлага, зохицуулалтаар хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Монгол Улсын Засгийн газар (танхим), сайд, дээд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад нэгж байх ба шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага байна.